

ЛАМ НАРЫН СЭТГҮҮЛИЙН ТУХАЙ

Л. Чулуунбаатар *

Энэ өгүүллийг 2003 оны намар болсон Японы монгол судлаачдын намрын эрдэм шинжилгээний ээлжит бага хуралд тавьсан бөгөөд Токиогийн Гадаад судлалын Их Сургуулийн профессор Окадо Казюүки авгай япон хэлээр орчуулж ТГСИС-ийн Соёлын Солилцооны Судалгааны Хүрээлэнгийн 2004 оны эрдэм шинжилгээний сэтгүүлийн 8-р ботийн 176-180-р хуудсанд хэвлүүлсэнд туйлаар талархаж явдаг билээ. Монголдоо ер хэвлүүлээгүй тул одоо үзэхэд бас ч зарим хүнд санаа авахад нь хэрэг болуужин хэмээн санах тул ийнхүү сургуулийнхаа эрдэм шинжилгээний сэтгүүлд судалгааных нь талаар жаахан дэлгэрүүлэн хэвлүүлж байгаа юм.

Өвгөдийн ярих нь "Лам нарын сэтгүүл" 6 дугаар гарсан гэдэг билээ. Энэ хугацаанд эрэн сурагласаар 1936 онд гарсан № 3, 4 мөн 1937 оны № 1, 2 болон № 5, 6 дугаар сэтгүүлийг олж авав. № 3, 4 нь нэг дэвтэр № 1, 2 болон № 5, 6 нь нэг дэвтэр болой. Хоёр дэвтэр хоёулаа монгол хэлээр, хоёр үсгээр хавсран хэвлэсэн боловч 1936 онд хэвлэгдсэн нь төвд үсгээр монгол хэлээр бичсэн нь эхэндээ, 1937 оных нь монгол бичгээр бичсэн сэдвүүд нь эхэндээ байна. Энэ нь лам нарын унших чадвар боломжийг харгалзан үзсэн хэрэг бололтой. Энэ хоёроос өөрийг олж үзээгүй тул ер нь энэ хоёр сэтгүүлд орсон 6 дугаараа хэлж байгаа юм биш үү гэдэг сэтгэгдэл төрсөн юм. Гэвч нарийвчлан, дахин нягтлан шалгах хэрэгтэй юм. Монгол хэлээр төвд үсгээр бичсэн зохиол бүтээлийн талаар гадаад дотоодын эрдэмтэд анхаарал хандуулж судалгаа хийсээр ирсэн билээ. Энэ талаар "Mongolian in Tibetan script" нэртэй анхны өгүүллийг Данийн эрдэмтэн Кааре Грөнбэч (Kaare Grønbech) 1953 онд бичиж, Studia Orientalia сэтгүүлд хэвлүүлсэн билээ. Өгүүлэлдээ тэрээр төвд үсгээр монгол хэлээр бичих явдал бол лам нарын хувьд "тогтсон тогтвортой хэм хэмжээ" хэмээн дүгнэсэн байдаг бөгөөд олон зуун жил хэрэглэж ирсэн хийгээд "лам нар амаар хоёр хэлрүү орчуулж чадах боловч бичгээр санаагаа илэрхийлэх үедээ гагц мэддэг төвд үсгээрээ илэрхийлэн бичих нь зайлигүй байсан юм" хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Энэ санааг Оросын эрдэмтэн А.М.Позднеев 1887 онд бичсэн "XIX зууны сүүл үеийн Монголын ламын шашин" номдоо анх гаргасан байдаг билээ. Алаксей Бобровников авгайн 1849 онд Казанд хэвлүүлсэн "Монгол-Халимаг хэлний зүй" хэмээх номдоо ч энэ талаар бас дурдсан зүйл буй. Кааре Грөнбэч бол Өвөрмонголд хийсэн Данийн эзэн хааны номын сангийн судалгааны экспедицийн бүрэлдхүүнд оролцон явж олон зуун монгол ном

* МУИС-ийн МХСС-ийн Гадаад хэлний тэнхим

¹⁾ P176-180 総合文化研究 VOL. 8 (2004)

цуглуулж, Данийн эзэн хааны номын сангийн монгол номын фондыг үндэслэн байгуулсан гавьяатан билээ. Хожим тэдгээр номын католог болон тайлбарыг “*Catalogue of Mongol books, manuscripts and xylographs*” хэмээх нэртэйгээр Вальтер Хайсэг (Walther Heissig), Чарльз Боодан (Charles Bawden) нар хамтран хийж 1971 онд хэвлүүлсэн юм. Үүний дараа профессор Т.Пагва “Төвд үсгээр үгчилсэн монгол ном зохиол” хэмээх томоохон хэмжээний өгүүлэл бичиж үсэг зүй, зөв бичлэгийн талаар нилээд чамбай тайлбарлаж 1957 онд хэвлүүлсэн бөгөөд академич Ц.Дамдинсүрэн авгай 1959 онд хэвлүүлсэн “*Монгол уран зохиолын дээж зуун билиг оршвой*” цоморлигтоо Гэлэгбалсангийн төвд үсгээр монгол хэлээр бичсэн “Наадмын ерөөл”² шүлгийг оруулж товч тайлбар хийсэн юм. Мөн энэ жил академич Б.Ринчин Ишдоржийн зохиосон “*Ye-šes-rdo-rje Bod-skad-kyi-brdah-gsar-rciñ-dkan-ba sog-skad-du-kah-li-sum-cuhi-rim-pas gtan-la-pheb-pahi-brdah-yig-mkhas-pa rgya-mcho-blo-gsal-mgul-rgyan-ces bya-ba-bžugs-so*”³ хэмээх төвд үсгээр бичсэн Төвд-Монгол толийг хэвлүүлсэн бөгөөд оршлын үгэндээ “*Монгол үгийг төвд үсгээр өөрийн нутгийн аялгууг баримтлан, аман бичгийн хэлний байдлаар тэмдэглэсэн нь монгол аялгууг судлах монголч эрдэмтэнд маш сонин чухал зүйл болжээ*” хэмээн цохон тэмдэглэсэн байдаг. Английн нэрт монголч эрдэмтэн д-р Чарльз Боодан “*Mongolian in Tibetan script*” хэмээх Кааре Грөнбэчтэй адил нэртэй өгүүлэл бичиж Studia Orientalia сэтгүүлд 1960 онд хэвлүүлсэн билээ. Гэсэн хэдий ч судлаачид лам нарын энэ сэтгүүлд дагнан анхаарал хандуулсан нь үгүй билээ. Т.Пагва багш болон Ч.Боодан нар дурдах төдий өнгөрсөн байдаг. Ч.Боодан дээр дурдсан өгүүлэлдээ ч энэ сэтгүүлийн талаар бас л цухас дурдсан байдаг юм. Харин Ч.Боодан “*Орчин үеийн монголын түүх*” номдоо “*нэг юмуу хоёр жил хэвлэгдсэн*”⁴ хэмээн дурдсан нь миний дээрх хоёр дэвтэрт орсон 6 дугаар бол нийт гарсан 6 дугаар мөн гэдгийг ялимгүй ч гэсэн баталгаажуулж байгаа юм. Д-р Л.Чулуунбаатар 2000 онд нийтлүүлсэн “*Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл*” хэмээх номдоо төвд үсгээр монгол хэлээр бичсэн зохиол бүтээлийн эгшиг гийгүүлэгчийн системийн талаар сайтар харьцуулан бичиж оруулсан байдаг. Өрнөдийн эрдэмтэдээс энэ сэтгүүлийн талаар анхаарал хандуулан дагнаж, товч судалгаа хийсэн хүн бол Америкийн судлаач Степани Гривелет (Stephane Grivelet) юм. Тэрээр 2001 онд Индианы Их Сургуулийн Монголын нийгэмлэгийн сэтгүүлд цувралын нэгэн дугаар болгож 1936 оны лам нарын сэтгүүлийг хуулбарлаж өмнө нь гурван хуудас судалгааны өгүүлэл оруулан “*The Journal of The Lamas: A Mongolian publication in Tibetan script*” хэмээх нэртэйгээр хэвлэж гаргасан юм. Энэ өгүүлэлдээ үсгийг оноосон байдалд нилээн сайн дүгнэлт хийсэн байдаг юм. Тэрээр “*Бичлэгийн хоёр ситемээр хавсран гаргасан нь төвд үсгээр бичигдсэн лам нарын сэтгүүл нь монгол бичвэрүүдийг илүү сайн ойлгоход тус болохоос гадна энэ салбар дахь үнэлж баршгүй чухал баримт юм*”⁵ хэмээн дүгнэсэн нь буй.

[illegible]

эээлж байсан лам нарыг үндэсний бичигт сургахыг нэн чухалчилж эхний үед сайн дурын бодлого баримтлан урсгалаар нь явуулж байснаа дараа нь сумын захиргаа, клуб, улаан булан, хүрээ хийдийг түшиглүүлэн байгуулсан бүлгэм дугуйланд зохион байгуулалттай хамруулан сургах болсон байна. Лам нарыг үндэсний бичигт сургахад эхэндээ орон тооны үсэг бичгийн багш ажиллуулж байгаад, сүүлдээ монгол бичигтэй сайн дурын лам нарыг багшаар ажиллуулах болжээ. 1935-1937 оны байдлаар 20 мянга гаруй залуу лам нар бичиг үсгийн бүлгэмд хамрагдах болжээ. Эхний дэвтэрийн зорилго бол төвд үсгийг бүх лам нар мэдэх учраас төвд үсгээр монгол хэлээр эхэлж уншаад суралцаж буй лам нар монгол бичгээр харьцуулан унших бололцоог бодолцсон бололтой. 1937 оны дэвтэрийн эхэнд нь монгол бичгээр сэдвүүдээ хэвлэсэн явдал бол олон хүрээ хийдийн лам нар монгол бичиг сурах хөдөлгөөнд хамрагдаж ихэнх нь монгол бичиг мэддэг болоод байсан тул ийнхүү эхэнд нь тавьсан байна. Жишээлбэл: Амарбаясгалант хийдийн 1937 оны бүртгэлд монгол бичиг мэдэх 18, монгол бичигт суралцаж байгаа 120 гэсэн тоо байгаа нь сүм хийд сургалтыг эрчимжүүлж байсны баталгаа юм. Шашны захиргааны 9-р хурлын тогтоол дотор *"шашин номын хэргийг эрхэлсэн нэгэн хэсэг лам бид нар нь угаас монгол хүн болохыг хэрхэвч умартаж ул болох тул, өөрийн үндэс язгуур ба засаг төр хийгээд ардын үндэсний соёл боловсролыг дээшлүүлэх хэрэгт санаа зовнин туслалцах нь чухал хэмээн үзмүй. Ер ч үндэсний монгол бичгийг суралцах явдал нь монголын ард түмний соёл боловсролыг дээшлүүлэх ба тусгаар тогтносон засаг төрийг улмаар батжуулах явдалд хамгийн чухал нөхцөл мөн болмой"*⁶ хэмээн тодорхой заасан байгаа болой. Лам нарыг бичиг үсэгт сургах болон лам нарын сэтгүүл гаргах цаг үеийн ямар шаардлага байсан бэ хэмээн асууж болох юм. 1928 оноос эхлэн тус орны зах зээлээс гадаадын капиталыг хүчээр хөөн гаргаж, чинээлэг аж ахуйг хавчин хязгаарлах феодалын болон томоохон аж ахуйг эдийн засаг улс төрийн талаар довтолх ангич бодлогыг хэрэгжүүлж эхэлжээ. Энэ үед Монгол оронд гадаадын 1080 гаруй пүүс байсан бөгөөд 800 гаруй нь хятадын, үлдэх хувь нь Орос, Герман, Итали, Франц, Англи, Америк, Япон, Дани, Энэтхэг зэрэг олон орны пүүс байсан хийгээд мал сүргийн ихэнх нь чинээлэг ард болон сүм хийдийн жасын мэдэлд байв. Энэ хүчирхийлэл нь монголын өвөрмөц нөхцөлд тохирохгүй байсны улмаас ардын бослого тэмцэл өрнөж олон мянган өрх айл хил даван нүүж, МАН, ардын засгийн нэр хүнд унаж иргэний дайн гарах ирмэг дээр ирэв. Иймд ЗОУ-ын удирдлага арга буюу Монгол дахь үйл ажиллагаагаа түр зогсоож монголыг монголоор нь удирдуулах боломжийг олгожээ.⁷ Лам нарын талаар анги ялгаварласан намын бодлогыг гажуудуулж лам нарыг нийтэд нь хавтгайруулан довтолсон зүүнтний гэм алдааг засаж лам нарыг ард түмний талд татах бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө тэмцсэн байна. Нугалааны үед дунд лам нарыг эсэргүү хэрэгт элдвээр холбогдуулсан завхрал гарсныг хянан үзэж эсэргүү хэрэгт үл холбогдогсдыг суллан цагаатгав. Бас хар болсон лам нарт сонгуулийн эрх эдлүүлсэн байна. Лам нарыг албадан хар болгохыг зогсоож, албаар хар болсон лам нар хэрэв хүсвэл эргэж лам болохыг зөвшөөрчээ. 1932-1934 онд 27 мянга гаруй хүн эргэж лам болжээ.⁸ Сүм хийдийг албадан хаах, хууль бусаар нэгжих хурал номын үйл ажиллагааг зүй бусаар үймүүлэхийг хориглов. Сүм хийд өөрийн

⁶) "Лам нарын сэтгүүл", 1936 (26) VIII. IX. № 3, 4, х 100-104

⁷) С.Отгонжаргал, "XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990), УБ, 2003, х 72-73

⁸) НАХ байгууллагын архив, 1935 оны сүм хийдийн талаар гаргасан дэлгэрэнгүй илтгэл.

харъяа жасдаа бүрэн эзэн байх эрхийг хэтэрхий үгүйсгэж байсныг бас зассан байна.⁹ 1932-36 онд том жижиг сүм хийд, хурлын газар 840 гаруй¹⁰ байсан бөгөөд тэнд 90 орчим мянган лам нар байжээ. Тэдний 18 мянга орчим нь сургуулийн насны хүүхэд байсан байна.¹¹ Дунджаар шашны хурал номын нэг газарт 900 орчим хүн, нэг ламд 10 хүн, гурван өрх оногдож байснаас ч үзсэн шарын шашин үлэмж нөлөөтэй оршсоор байсан нь илэрхий. Лам нарын хэрэгцээнд жилд дунджаар 31 сая төгрөгийн хөрөнгө зарагдаж байсан нь тэр үеийн ардын сургуулийн нэгэн жилийн зардлаас 16 дахин их байлаа.¹² Тийм болохоор Засгийн газар лам нарыг аль болохоор гэгээрүүлэн ухамсарлуулж хар болгон улсын хөдөлмөрт татан оролцуулахыг эрмэлзэж байв. Зөвхөн 1936 онд мал аж ахуй, үйлдвэр, тээвэр, худалдааны ажилд 10 мянга гаруй лам нар шилжин ажиллажээ.¹³ Нийгмийн ашигтай хөдөлмөр хийхийг сонирхсон доорд лам нарт улсаас элдэв тусламж дэмжлэг үзүүлэх, бүх төрлийн татвараас хөнгөтгөх хэлтрүүлэх арга хэмжээ авав. 1936 онд аж ахуйд гарах доорд лам нарт зориулж улсаас 500 000 төгрөгийн зээллэгийн фонд гаргажээ. 1936 онд хөдөө аж ахуйд гарч ажилласан 200 гаруй лам нарт 114 000 төгрөгийн зээллэг өгчээ.¹⁴ Лам нарыг нийгмийн ашигтай хөдөлмөрт татан оруулах чухал нэг хэлбэр нь доорд лам нарын артель байлаа. МАХН, засаг доорд лам нарыг үйлдвэр, хамтын аж ахуйд татан оруулах ажлыг 1935 оноос туршиж үзсэний эцэст 1937-1938 онд лам нарын дотор өргөн хөдөлгөөн болгон зохион байгуулжээ. 1938 онд ядуу лам нарын гар үйлдвэрийн 120 артель байгуулагдаж, түүнд 5000 гаруй лам нар оржээ.^{15/16} Гэсэн хэдий ч олон улсын байдал ноцтой хүндэрч, ЗХУ болон коминтерний эсрэг Герман, Итали, Японы гурвын гэрээ байгуулагдаж, дэлхийн хоёрдугаар дайн дэгдсэн нөхцөлд Сталин Монгол орныг баттай ар талаа болгох бодлогоо шуурхайлж эхэлжээ. Тэрээр нам төрийн гол удирдагчид болох А. Амар, П. Гэндэн, Х. Чойбалсан нарыг удаа дараа тухайлбал, улсын ерөнхий сайд П.Гэндэнг таван удаа, А.Амарыг нэг удаа, Х.Чойбалсанг долоон удаа хүлээн авч уулзахдаа хар шар феодал, лам нарын үлдэгдлийг устгахыг шаардсаар байв. Энэхүү шаардлагыг П. Гэндэн, А. Амар нар боломжгүй хэмээн хүлээж аваагүйгээр барахгүй зүйл бүрээр эсэргүүцэж байв.

И.В. Сталингаас лам нараа ангийн дайсан хэмээн устгахыг шаардахад П. Гэндэн *"Манай улс хүн ам цөөтэй учир лам нараа хар болгож ажил хийлгэнэ"*¹⁷ хэмээн ээсэргүүцжээ. Мөн тэрчлэн П.Гэндэн *"... тус улсын гадаад байдал түгшүүртэй байх үед лам нарын асуудлыг хурцатгаж, тэд нартай тэмцэх гэсэн хүн бол хувьсгалын эсэргүү"*

⁹) БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х. 301

¹⁰) МАХН-ын төв архив, ф-1 ХН.7 124-р тал

¹¹) МАХН-ын IX их хурал дээр үндэсний соёл, боловсролыг хөгжүүлэхэд намаас тавих зорилгын тухай илтгэл, УБ, 1934, 13-р талд

¹²) БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х. 342

¹³) Намын амьдрал сэтгүүл, 1964 он, № 3 31-р тал

¹⁴) МАХН-ын ТА, ф. 1, т. 6, хн. 51 81-р тал

¹⁵) БНМАУ-ын гар үйлдвэрлэлийн хоршооллын анхдугаар их хурлын илтгэл тогтоол, 1940 он, 33-35-р тал

¹⁶) БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х. 350

¹⁷) С.Отгонжаргал, "XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй", (1921-1990), УБ, 2003, х. 73

болно" ¹⁸ хэмээн лам нарыг хамгаалах талд тууштай зогсож байсан билээ. Яагаад Сталин ингэж лам нарыг ангийн дайсан хэмээн устгахыг эрчимтэй эрмэлзэж байсан бэ гэвэл анхнаасаа 1911 оны үндэсний чөлөөлөх хөдөлгөөн болон 1920 оны Монгол Ардын Намын гишүүдийн ихэнх нь эрдэм чадалтай лам нар байсан бөгөөд мөн тэрчлэн Ардын засгийн анхны ерөнхий сайд нар бас л эрдэм төгс дээд лам нар байсан билээ. Тэд нар шашин соёл, үндэсний онцлогоо ямагт хадгалахыг хичээж Монголоо монголоор удирдахыг хичээж, тэдний заавар журмыг тэр болгон дагахгүй, бодлогоо хэрэгжүүлэхэд нь том хаалт болж байсанд оршино. Улс төрийн нөхцөл байдал иймэрхүү байсан учраас лам нарыг ухамсарлуулах үндсэн дээр боловсролтой болгох, хар болгож, хөдөлмөрт татан оролцуулах ажлыг дэс дараатай хийж энэ хэрэгт сүм хийдийн захиргааг татан оролцуулж байсныг энэ сэтгүүлээс харж болох юм. 1936 оны сэтгүүлийн гарчгийг жагсаавал:

Оршил

1. Шашны захиргааны 9-р их хурлын тогтоол
2. Шашны захиргааны дүрэм
3. Лам нарын тухай засгийн бодлого
4. Сэтгүүлийн хашаанд орхисон нэргүй бичгийн хариу
5. Улсын дээд шүүхээс тасалсан нэгэн хэрэг
6. Лам нарын дотор үүсч буй үйлдвэрийн тухай мөн илтгэл ба тайлан
7. Дотоод монголоос оргож ирсэн нэгэн ламын ярьсан зүйл
8. Орлого бүхий лам нарт албан татвар ноогдсон тухай
9. Лам хүүхдийн бичиг үсгийн сургууль
10. Завханаас ирүүлсэн захидал
11. Завхан дахь сурвалжлагчаас бичсэн зүйл
12. Зарим хуурамч явдлыг илрүүлэн шүүмжлэх нь
13. Орон нутгийн тусламж ба захидалууд ¹⁹
- 14.

1937 оны сэтгүүлийн гарчгийг жагсаавал:

1. Шашны захиргааны 9-р их хурлын тогтоолын явц
2. Үнэн худлын тодорхой ялгавар хэмээх оршвой
3. Лам нарт таниулах хэмээсэн товч өгүүлэл
4. Өлгийн ба Егзөрийн хийдийн хэсэг урвасан лам нарын хэргүүдийн тухай хоёр зүйл
5. Манай улсын доторхи олон хүрээ хийдийн дотор юу болж байгаа буй
6. Орон нутгийн сурвалжлагч нар ба бусад лам нараас бичсэн санал шүүмжлэлүүд
7. Болох эсэхийг бусдын анхааралд талбимуй
8. Орон нутгийн сайшаал ба тусламжууд ²⁰ гэсэн сэдвүүд байгаа болой.

Эдгээр сэдвээс харахад тэр үеийн засгийн бодлогыг тодорхой тусгаж байсан нь илэрхий харагдаж байгаа болой. Мөн энэ сэтгүүлийн хамгийн гол зорилго бол лам

¹⁸) БНМАУ-ын түүх, (Гутгаар боть). Улаанбаатар, 1969) х. 356

¹⁹) "Лам нарын сэтгүүл", 1936 (26) VIII. IX. № 3, 4, х 89

²⁰) "Лам нарын сэтгүүл", 1937 оны 1 ба 2-дугаар бөгөөд 5, 6 дугаар сэтгүүл, х 2

нарыг монгол бичигт сургах, худал ташаа мэдээллийг арилгаж үнэн зөв мэдээлэл лам нарт хүргэх зорилготой байсан байна. Энэ тухай сэдэв бүрээр задлан яривал маш урт зүйл болох бөгөөд энэ удаа тийм зорилго тавиагүй тул үүгээр товчилъё. Ер нь түүх бичлэгийн асуудалд лам нарын энэ сэтгүүлээс баримт болгон ашигласан зүйл туйлын хомс байдаг бөгөөд ганц хоёр мөрийг иш татсан зүйл мэр сэр тааралддаг. Энэ нь үзэл суртлын хатуу хүлээсийн улмаас уншиж ашиглах байтугай харах ч хориотой байсанд оршино. Социалист номлолын үед лам нарыг шашнаар мунхруулагчид хэмээн ухуулдаг байсан тул дунд үеийнхэн тэдний талаар туйлын ташаа ойлголттой байдаг болой. Тэд ямарч үед оюуны соёлыг түгээн дэлгэрүүлэгч, хөгжүүлэгч байсан гэдгийг энэ сэтгүүл болон түүхийн олон баримт нотолдог билээ.

Энэ сэтгүүлийг үзээд дараах хэдэн дүгнэлт гарч байна.

1. Сэтгүүлийн бичвэрүүд нь 30-аад оны түүх бичлэгт чухал хэрэглэгдхүүн болох юм.
2. Тэр үеийн хүрээний лам нарын ярьж байсан аман аялгууг төвд үсгээр буулган бичсэн нь аялгуу судлалын хувьд үнэт хэрэглэгдхүүн болно.
3. Урьд өмнөх төвд үсгээр монгол хэлээр бичиж тэмдэглэж байсан туршлагаудыг нэгтгэн нэгэн мөр болгон төвд үсгээр бичих системийг үндсэнд нь тогтоож өгсөн гэж хэлж болох юм.

НОМЗҮЙ

1. БНМАУ-ын түүх, (Гутгаар боть) (1969), Улаанбаатар.
2. БНМАУ-ын гар үйлдвэрлэлийн хоршооллын анхдугаар их хурлын илтгэл тогтоол (1940).
3. Bawden Charles (1989 [1968]), *The Modern History of Mongolia*, London.
4. *ᠮᠤᠩᠭᠣᠯᠤᠯᠤᠰ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ ᠤᠨ ᠤᠯᠤᠰ* · Corpus Scriptorum Mongolorum, tomus XIV, *ᠮᠤᠩᠭᠣᠯᠤᠯᠤᠰ* · 1959
5. "Лам нарын сэтгүүл", 1936 (26) VIII. IX. № 3, 4
6. "Лам нарын сэтгүүл", 1937 оны 1 ба 2-дугаар бөгөөд 5, 6 дугаар сэтгүүл.
7. МАХН-ын төв архив, ф-1 ХН.7
8. МАХН-ын ТА, ф. 1, т. 6, хн. 51
9. МАХН-ын IX их хурал дээр үндэсний соёл, боловсролыг хөгжүүлэхэд намаас тавих зорилгын тухай илтгэл, УБ
10. С.Отгонжаргал (2003), "XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй" (1921-1990), Улаанбаатар.
11. Намын амьдрал сэтгүүл, 1964 он, № 3
12. НАХ байгууллагын архив, 1935 оны сүм хийдийн талаар гаргасан дэлгэрэнгүй илтгэл.
13. Л.Чулуунбатар (2000/2001), "Нүүдэлчин Монголчуудын бичиг үсгийн соёл", Улаанбаатар.
14. Stephane Grivelet (2001), *"The Journal of The Lamas: A Mongolian publication in*

Tibetan script", Bloomington. P VI.

15. Ye-šes-rdo-rje Bod-skad-kyi-brdah-gsar-rciñ-dkan-ba sog-skad-du-kah-li-sum-cuhi-rim-pas gtan-la-pheb-pahi-brdah-yig-mkhas-pa rgya-mcho-blo-gsal-mgul-rgyan-ces bya-ba-bžugs-so, Corpus Scriptorum Mongolorum, tomus IV, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1959.
16. 総合文化研究 VOL. 8 (2004).

SUMMARY

According to elders' accounts, six issues of the *Lam naryn setguul* (*Lamas' Magazine*) were published. We were able to locate copies of nos. 3 and 4 from 1936, as well as nos. 1, 2, 5 and 6 from 1937. Numbers 3 and 4, 1 and 2, and 4 and 5 were published as combined issues. The two issues are both in Mongolian language written in two different scripts, though the 1936 issues have Mongolian language text in Tibetan script first, while the 1937 issues have articles in the Mongolian script first. This arrangement likely reflects the literacy and reading skills of the monastic audience.

Our study of this magazine leads to the following conclusions:

1. The articles published in this magazine constitute an important historical source for the study of events of the 1930s.
2. The transcription of Khuree lamas' spoken language using Tibetan characters provides valuable insight into speech patterns at that time.
3. This publication essentially established a definitive system for writing Mongolian-language texts using Tibetan characters, unifying the previously existing systems.